



БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

2022 оны III улирлын тайлан

ӨВӨЛДБЭЛЭНҮҮ?

Урт өвөл хүлээж байна.

Банкны салбарын үзүүлэлт харьцангуй тогтвортой, өсөлттэй байлаа. Банкны салбарын нийт актив өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 хувиар нэмэгдлээ. Чанаргүй зээл нэмэгдэх төлөвтэй байна. Гадаад орчны тодорхой бус байдлаас шалтгаалан иргэдийн дунд валют нөөцлөх, валют хадгалах сонирхол өндөр байгаа нь төгрөгийн хадгаламж буурахад нөлөөлжээ.

Орос-Украины асуудал болон цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалсан нийлүүлэлт, логистикийн хүндрэл нь манай улсын гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнэд нөлөөлж, инфляцын түвшин өндөр хэвээр хадгалагдах гол шалтгаан болж байна.

Мөн уул уурхай, тээврийн салбарын сэргэлт удаашралтай байгаа нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж буй хэдий ч үйлчилгээ, худалдаа, барилга болон хөдөө аж ахуйн салбарын сэргэлт харьцангуй хурдан байсан нь эдийн засаг 3.7 хувиар өсөхөд чухал нөлөө үзүүллээ.

Цар тахлын үед эдийн засгийн салбаруудыг ганц дэмжиж ирсэн банкны салбарын зээлийн өсөлт үргэлжилсээр байна. Тээвэр логистикийн хүндрэлийг алхам алхмаар хурдацтайгаар шийдвэрлэн уул уурхай, тээврийн салбарын сэргэлтийг дэмжихгүй бол эдийн засаг тогтвортой өсөх боломжгүй нь харагдлаа.

Сүүлийн 3 улирал дараалан төлбөрийн тэнцэл алдагдалтай байгаа нь валютын нөөцөд дарамт учруулаад зогсохгүй төгрөгийн худалдан авах чадварыг бууруулах өндөр эрсдэлтэй байна.

Энэ оны сүүлийн улиралд эдийн засгийн нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөхөөс хамаарч эдийн засагт тулгараад буй өвөл хэр удаан үргэлжлэх нь тодорхойлогдоно. Цаашлаад Монгол Улс ОУВС-гийн хөтөлбөрт хамрагдах замаар эдийн засгаа тогтворжуулах хэрэгцээ үүсэх дүр зурагтай байна.




Иргэд хэрэглээний зээл түлхүү авч байна.

Банкууд иргэдэд хэрэглээний зээл буюу цалин, тэтгэвэр болон хадгаламж барьцаалсан зээлийг түлхүү олгожээ.

Онцлох өөрчлөлт,
энгийн тайлбар

Иргэдийн зээл олголт, жил бүрийн III улирал



Онолын тодорхойлолт

Банкны шинээр олгосон зээл

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг.

Шинээр иргэдэд олгосон зээлийн хэмжээ нэмэгдэв.

21%

2022 оны III улирлын
гүйцэтгэл

2022 ОНЫ III УЛИРАЛД БАНКНЫ САЛБАРТ ГАРСАН ОНЦЛОХ ӨӨРЧЛӨЛТ, ЦААШДЫН ХАНДЛАГА



Банкуудын иргэдэд олгосон зээлийн хэмжээ өсөлттэй байна. Гэхдээ худалдааны салбараас бусад салбарт зээл олголт буурчээ.



Банкуудын зээлийн чанар муудах төлөвтэй байна.



Тээвэр логиستيкийн үйл ажиллагаа аажмаар сэргэж буй нь барилга, боловсруулалтын салбарын өсөлтөд чухал үүрэг гүйцэтгэлээ.



Системийн нөлөө бүхий 5 банкны санхүүгийн үзүүлэлт өсөлттэй байна.



Төлбөрийн тэнцлийн алдагдал тасралтгүй үргэлжилж валютын нөөцөд дарамт учруулах эрсдэл өндөр байна.



Цар тахлын болон геополитикийн нөхцөл байдлаас үүдэлтэй тодорхой бус байдал нь импортын гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдэх суурь шалтгаан болж байна.

БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2022 оны III улирал

Бодлогын хүү нэмэгдсэн нь банкны салбарын зээлийн өсөлтийг саарахад нөлөөлөв.

Хэдий банкны салбарын зээлийн өсөлт удааширсан хэдий ч эдийн засгийг дэмжих гол хөдөлгүүр хэвээр байна.


Банкны зээлийн багц

Жич: Зээлийн үлдэгдэл нь шинээр олгосон зээлээр нэмэгдэж, эргэн төлөлтөөр буурч байдаг.

+14%

Зээлийн үлдэгдэл
дунджаар 14 хувиар өсөв.


Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо




Иргэд хэрэглээний зээл түлхүү авч байна.

Банкууд иргэдэд хэрэглээний зээл буюу цалин, тэтгэвэр болон хадгаламж барьцаалсан зээлийг түлхүү олгожээ. Худалдааны салбараас бусад салбарт зээл олголт буурчээ.

Иргэдийн зээл олголт, жил бүрийн III улирал



Бизнесийн зээл олголт, жил бүрийн II улирал



Банкны шинээр олгосон зээл

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг.

Иргэдэд олгосон зээл

21%

НЭМЭГДЭВ.

Банкны зээлийн чанар

Жич: 90 хоногоос дээш хугацаагаар зээлээ төлөөгүй нөхцөлд чанаргүй зээлд шилждэг.

Салбарын хэмжээнд 10
зээл тутмын 1 нь чанаргүй
байна.

12%

Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо


Зээлийн багцын чанар муудаж байна.

Иргэдийн хэрэглээний зээлийн чанаргүйдэл хэвийн түвшинд байна.


Банкууд активын чанарын үнэлгээ хийлгэсэн нь зээлийн чанаргүйдэл нэмэгдэхэд нөлөөлөв.

Салбаруудын сэргэлт удаан байгаа нь бизнесийн зээлийн чанарт нөлөөлсөн хэвээр байна.

Иргэдийн чанаргүй зээлийн харьцаа, жилийн бүрийн III улирал




Бизнесийн чанаргүй зээлийн харьцаа, жилийн бүрийн III улирал



Гадаад орчны тодорхой бус байдал, хэрэглээний үнийн өсөлтөөс шалтгаалан иргэдийн төгрөгийн хадгаламж буурчээ.

Гадаад орчны тодорхой бус байдлаас үүдэлтэй валют хадгалах, нөөцлөх сонирхол иргэдэд их байна. Иргэд хадгалахаас илүүтэйгээр хэрэглэх сонирхол өндөр байна. Төгрөгийн хадгаламжийн бодит өгөөж инфляцаас шалтгаалан буурсан нь иргэдийн төгрөгийн хадгаламж буурахад нөлөөлөө.

Банкны эх үүсвэр, жилийн бүрийн III улирал



Банкны эх үүсвэр

Жич: Энэ нь банкны татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийг хэлдэг.

Валютын харилцах

2

дахин нэмэгджээ.

Банкны жигнэсэн дундаж хүү

Жич: Банкуудын шинээр татсан эх үүсвэрийн хүү, олгосон зээлийн хүү нь цаг хугацаа, мөнгөн дүнгийн хувьд жинлэгдсэн дундаж хүүг хэлнэ.


Хадгаламжийн хүү

8.8%

Эх сурвалж: Монголбанк

Хадгаламжийн хүү нэмэгдэх хандлагатай байна.

Төв банкнаас гадаад, дотоод эдийн засгийн нөхцөлд үүсэж буй тодорхой бус байдлаас шалтгаалан бодлогын хүүгээ нэмэгдүүлсэн нь хадгаламжийн хүүг аажмаар нэмэгдэх хүлээлтийг бий болгож байна.



БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2022 оны III улирлын гүйцэтгэл

Банкны актив буюу хөрөнгө

Жич: Банкны нийт өр төлбөр дээр нэмэх нь эздийн өмчийг бүхэлд банкны хөрөнгө буюу актив гэнэ.

Системийн нөлөө бүхий
банкуудын актив


1%

ӨСӨВ.

Банкны системийн нийт актив өмнөх оны мөн үеэс 500 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Голомт банкны актив 11% - иар өсжээ. Харин Худалдаа, хөгжлийн банкны актив 5% - иар буурсан байна.

Банкуудын актив жил бүрийн III улирлын байдлаар




2020	2021	2022	2020	2021	2022	2020	2021	2022	2020	2021	2022	2020	2021	2022
Хаан			ХХБ			Голомт			Төрийн банк			Хас		

Банкны салбарын нийт эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 65 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Хаан банкны эх үүсвэр 0.4 их наяд төгрөгөөр, Төрийн банкны эх үүсвэр 0.2 их наяд төгрөгөөр буурчээ. ХХБ, Голомт болон Хас банкны эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэмэгджээ.

Банкуудын эх үүсвэр, жил бүрийн III улирал



Банкны эх үүсвэр

Жич: Иргэд, байгууллага болон хөрөнгө оруулагчдаас татсан өр төлбөрийн хэмжээ.

Банкуудын эх үүсвэр

0.25%

нэмэгджээ.

Өөрийн хөрөнгийн өгөөж

Жич: Тухайн байгууллага нь өөрийн хөрөнгөө хэр үр ашигтай зарцуулж буй тухай мэдээлэл өгдөг. Өөрөөр хэлбэл компани хөрөнгийг хэрхэн ашиг болгож буйг илэрхийлдэг үзүүлэлт юм.

Банкуудын өөрийн
хөрөнгийн өгөөж дунджаар


15%

Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

Банкуудын хөрөнгийн өгөөж хадгаламжийн өгөөжөөс хоёр дахин их байна.

Системийн нөлөө бүхий банкуудын өөрийн хөрөнгийн дүн 4.2 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 16 хувиар өсжээ. Өөрийн хөрөнгөөр буй болгосон ашгийн хэмжээ өндөр байна.


Банкуудын өөрийн хөрөнгийн өгөөж, жил бүрийн III улирал



Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ нэмэгджээ.

Банкууд эдийн засгийг дэмжих, гол салбаруудын сэргэлтийг дэмжих хангалттай өөрийн хөрөнгөтэй байна. Төрийн банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ нэмэгджээ.

Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ, жил бүрийн III улирал



2020	2021	2022	2020	2021	2022	2020	2021	2022	2020	2021	2022	2020	2021	2022
Хаан			ХХБ			Голомт			Төрийн банк			Хас		

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Жич: Санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс гарах алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгөтэй эсэхийг тодорхойлсон үнэлгээг хэлдэг

Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний дундаж

17%

Хөрвөх чадварын харьцаа

Жич: Богино хугацаат төлбөрүүдийг цаг тухайд нь төлөх чадварыг хэмждэг харьцаа.

Системийн нөлөө бүхий банкуудын хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтийн дундаж


35%

Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

Системийн нөлөө бүхий 5 банкны хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт өндөр хэвээр байна.

Иргэдэд олгож буй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад өсөлттэй байна. Хаан болон Хас банкны хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт өнгөрсөн жилтэй харьцуулахад буурсан хэдий ч хөрвөх чадвар өндөр хэвээр байна.

Банкуудын хөрвөх чадварын харьцаа, жил бүрийн III улирал



2020	2021	2022
Хаан		

2020	2021	2022
ХХБ		

2020	2021	2022
Голомт		

2020	2021	2022
Төрийн банк		

2020	2021	2022
Хас		

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

2022 оны III улирал: Эдийн засгийн өсөлт 3.7 хувьтай гарлаа. Үйлчилгээ, худалдааны салбарын сэргэлт харьцангуй хурдан байгаа бол боловсруулах үйлдвэр, барилгын салбарт үүсээд байсан хүндрэлүүд аажмаар арилж байгаа нь эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөллөө. Тээвэр логистик, хил гаалийн нөхцөл байдал сайжирч байгаа нь уул уурхайн салбарын сэргэлтийг дэмжих төлөвтэй байна.


Төлөв байдал: Хэрэв цаашид хил, гаалийн нөхцөл байдал хэвийн байдалтай, урд хөршийн Ковид-19 цар тахлын эсрэг баримталж буй бодлого суларвал уул уурхайн салбарын өсөлт эрчимжиж эдийн засгийн нөхцөл байдал сайжрах хүлээлтийг буй болгож байна. Харин Орос-Украины нөхцөл байдал удаан үргэлжлэх нь манай улсын гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнэд нөлөөлж цаашлаад иргэдийн худалдан авах чадвар, эдийн засгийн нөхцөл байдалд сөрөг үр дагаврыг буй болгох эрсдэлтэй. Нийлүүлэлтээс үүдэлтэй инфляцын түвшин өндөр байгаа нь цаашид хадгалагдах төлөвтэй байна.

2022 оны III улирлын байдлаар эдийн засаг 3.7 хувиар өсөв.

Үйлчилгээний салбарын тэр дундаа бөөний, жижиглэн худалдааны салбарын сэргэлт хурдацтай байгаа нь эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө үзүүллээ.

Хөдөө аж ахуй, боловсруулах болон барилгын салбар аажмаар сэргэж байгаа нь эдийн засгийн өсөлтийг дэмжлээ.

Эдийн засгийн дотоод эрэлт сэргэж буй нь эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлж байна.




Гадаад худалдааны тэнцэл өмнөх оны мөн үеэс 89 хувиар өсжээ.

Нүүрсний экспорт 53 хувиар, алтны экспорт 26 хувиар нэмэгдсэн нь худалдааны тэнцэл ашигтай гарахад чухал үүрэг гүйцэтгэлээ. Импортын бараа бүтээгдэхүүний бодит хэмжээ өсөлтгүй байгаа хэдий ч гадаад зах зээл дээрх үнийн өсөлтөөс шалтгаалан импортын хэмжээ цаашид ч нэмэгдэх төлөвтэй байна.


Хил, гаалийн хязгаарлалт болон тээвэр
логистикийн хүндрэл аажмаар буурч
байгаа нь экспорт нэмэгдэхэд нөлөөлжээ.



Импортын хэмжээ цаашид нэмэгдэх
төлөвтэй байна.



Экспортын нөхцөл байдал
сайжирч худалдааны тэнцэл
ашигтай гарлаа.




Төлбөрийн тэнцлийн алдагдал тасралтгүй үргэлжилж гадаад валютын нөөцөд дарамт болох эрсдэл өндөр байна.

Экспортоос илүүтэйгээр импортолж буй нь төлбөрийн тэнцэл 301 сая ам.долларын алдагдалтай гарахад нөлөөллөө.


Экспортын үйл ажиллагаа эрчимжиж эхэлсэн нь төлбөрийн тэнцэлд эергээр нөлөөллөө.

Төгрөгийн бодит ханш суларч манай улсын бараа, бүтээгдэхүүн бусад улстай харьцуулахад хямдарч байна.

3-4 сарын импортын хэрэгцээг хангах валютын нөөцтэй байна.



Төлбөрийн тэнцлийн алдагдал үргэлжилж байна.




Нийлүүлэлтээс үүдэлтэй инфляцын түвшин өндөр хэвээр байна.

Гадаад орчны тодорхой бус байдлаас шалтгаалан импортын шатахуун, хүнс, үйлдвэрлэлийн бусад чухал орцуудын үнэ өссөн нь нийлүүлэлтийн гаралтай инфляцын түвшин өндөр хадгалагдах гол хүчин зүйл болоод байна.

Хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 32 хувиар өссөн нь инфляцын түвшин өндөр байхад чухал нөлөө үзүүлж байна.

Инфляцын түвшин сүүлийн 3 сар дараалан буурлаа.




Төсвийн тэнцэл 962.1 тэрбум төгрөгийн алдагдалтай хэдий ч өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурсан байна.


Төрөөс олгож буй эрчим хүч, шатахууны татаасны өсөлт нь нийт төсвийн зарлагын дийлэнх хувийг бүрдүүлж байна. Үндсэн тэнцэл ашигтай гарч төсвийн алдагдлын дарамт буурах төлөвтэй байна.

Төсвийн орлого өмнөх оны мөн үеэс
12.7 хувиар нэмэгджээ.


ДНБ-д эзлэх хувиар




Нийт төсвийн зарлага буурах төлөвтэй
байна.



Төсвийн алдагдал өмнөх оны мөн үеэс
24.7 хувиар буурчээ.




ОУВС-гаас манай улсад хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд




ОУВС-гийн хөтөлбөрт хамрагдах нөхцөл байдал үүссэн үү?

Ковид-19 цар тахал болон Орос-Украины асуудлаас шалтгаалан манай улсын эдийн засгийн сэргэлт удаашралтай байна. Дотоод эрэлт аажмаар сэргэж импортын бараа бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжсэнээр төлбөрийн тэнцэл сүүлийн 3 улирал дараалан алдагдалтай гарлаа. Ирэх онд манай улс гадаад бондуудын эргэн төлөлтийг хийх бөгөөд энэ нь валютын нөөцөд дарамт учруулах хүлээлтийг буй болгож байна.

Валютын орох урсгал буурч төлбөрийн тэнцэл алдагдалтай хэвээр байна.



Оны эхнээс ам.долларын эсрэг төгрөг 17 хувиар суларчээ.



Валютын нөөц аажмаар буурч 3 сарын импортын хэмжээтэй тэнцэж байна.

